

## ШҮҮХЭЭС ТОРГУУЛИЙН ЯЛ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛ, УГ ЯЛЫН БИЕЛЭЛТИЙГ СУДАЛСАН ТУХАЙ ТОЙМ

2004 оны 07 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвөөс 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс 2004 оны 1 дүгээр улирлыг дуустал хугацаанд Монгол Улсын шүүхийн хэмжээнд торгуулийн ял оногдуулж буй шүүхийн практик, уг ялын биелэлтийн талаар судалж үзлээ.

Судалгааны зорилго нь Эрүүгийн шинэ хуулиар торгуулийн ял шийтгэлийн хэмжээ эрс нэмэгдсэнтэй холбогдуулан түүний биелэлтийн байдал, торгуулийн ялын хэмжээ нь амьдралд хэр нийцэж байгааг судлахад оршино.

Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар торгуулийн ял шийтгэлийн доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин  $/40000 \times 5 = 200000/$ , дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин  $/40000 \times 500 = 20000000$  төгрөг/ нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар тогтоогджээ.

Эрүүгийн шинэ хууль хучин төгөлдөр болсон өдрөөс буюу 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс 2004 оны 1 дүгээр улирлыг дуустал хугацаанд улсын хэмжээнд бүх шүүх 1118 хүнд нэг тэрбум 534 сая 659027 төгрөгийн торгууль оногдуулсан байна. Үүнээс 363 сая 787190 төгрөг ийм торгуулийн ял биелэгдэж, 721 сая 607200 төгрөгийн торгууль огт биелэгдээгүй байна. Мөн 21 хүний 92 сая 716000 мянган төгрөгийн торгуулийн ялыг баривчлах ялаар сольж, 14 хүний 75 сая 367250 төгрөгийн торгуулийн ялыг хорих ялаар сольсон байна. Торгуулийн ял шийтгүүлэгсдээс 30 хүн оргон зайлсан ба шүүхүүд 253 сая 416612 төгрөгийн торгуулийн ялыг албадан гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх хуудсыг харъяаллын шийдвэр гүйцэтгэлийн албадад нь шилжүүлсэн байна.

Торгуулийн ял оногдуулсан байдлыг шүүхээр нь авч үзвэл Нийслэлийн дүүргийн шүүхүүд 428 сая 268250 төгрөгийн, Сэлэнгэ аймгийн шүүх 143 сая 430500 төгрөгийн, Төв аймгийн шүүх 129 сая 758900 төгрөгийн, Дорноговь аймгийн шүүх 103 сая 104750 төгрөгийн торгуулийн ял оногдуулсан нь бусад аймгийн шүүхүүдтэй харьцуулахад хамгийн их байна.

Ялын биелэлтийн байдлыг авч үзвэл Нийслэлийн дүүргийн шүүхүүд 120 сая 74250 төгрөгийн, Сүхбаатар аймгийн шүүх 29 сая 434750 төгрөгийн, Булган аймгийн шүүх 21 сая 383250 төгрөгийн, Дорноговь аймгийн шүүх 20 сая 556250 төгрөгийн торгуулийн ялыг бүрэн биелүүлсэн байна.

Торгуулийн ял оногдуулсан байдлыг оноор нь авч үзвэл; 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс 2002 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд улсын хэмжээнд 179 сая 221890 төгрөгийн торгуулийн ял оногдуулснаас 79 сая 833290 төгрөгийн торгуулийн ял биелэгдэж, 58 сая 853000 төгрөгийн торгууль биелэгдээгүй, 2003 онд 978 сая 413387 төгрөгийн торгууль оногдуулснаас 223 сая 327450 төгрөгийн торгууль биелэгдэж, 392 сая 080700 төгрөгийн торгууль

биелэгдээгүй, 2004 оны 1 дүгээр улиралд 377 сая 23750 төгрөгийн торгууль оногдуулснаас 60 сая 626750 төгрөгийн торгууль биелэгдэж, 270 сая 673500 төгрөгийн торгууль биелэгдээгүй судалгаа гарч байна.

Дээрх судалгаанаас дүгнэлт хийвэл 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс 2004 оны 1 дүгээр улирлыг дуустал хугацаанд оногдуулсан торгуулийн нийт ял шийтгэлийн 23,8% биелэгдсэн байх ба оноор нь авч үзвэл; 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс 2002 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд оногдуулсан торгуулийн ялын 44,8%, 2003 онд оногдуулсан торгуулийн ялын 23,2%, 2004 оны 1 дүгээр улиралд оногдуулсан торгуулийн ялын 16,0% нь биелэгдсэн дүн гарч байна.

Шүүхүүд ихэвчлэн Эрүүгийн хуулийн 89, 99, 145, 146,148, 150, 151, 152, 155,175, 181, 215, 216, 230, 233 дугаар зүйл хэсгүүдэд заасан гэмт хэрэгт торгуулийн ял оногдуулж байгаа бөгөөд ялангуяа Эрүүгийн хуулийн 99, 175, 145, 151, 155, 215 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэгсдэд торгуулийн ялыг түгээмэл оногдуулжээ.

Шүүхүүд дээр дурьдсэн зүйл, заалтад зааснаар 10000-аас 12 сая хүртэл төгрөгийн хэмжээтэй торгуулийн ял оногдуулсан байх ба хамгийн их хэмжээтэй торгуулийг Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан байна. Энэ зүйлд зааснаар торгуулийн ялын хэмжээг 7530000-аас 12 сая хүртэл төгрөгөөр торгох ял оногдуулсан нь шүүхээс оногдуулсан торгуулийн ялын хамгийн дээд хэмжээ байна.

Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3 дахь хэсэгт заасан ял шийтгэлийн биелэлтийн байдлыг авч үзвэл шүүхүүд энэ зүйл, хэсэгт зааснаар 119 хүнд торгох ял оногдуулснаас 15 хүн буюу ял шийтгүүлэгсдийн 12,6 хувь нь уг торгуулийн ялыг биелүүлсэн байна.

Дээрх байдлуудаас дүгнэлт хийж үзэхэд торгуулийн ял шийтгэлийн биелэлтийн улсын дундаж 23,4%-тай байгаа нь маш доогуур үзүүлэлт бөгөөд одоогийн байдлаар цалин калений доод хэмжээ 40000 төгрөг, "Монголчуудын ихэнх нь дундаж амьдралтай" гэж бусад байгууллагаас хийсэн судалгаанд дурьдсан байх тул 200000-аас 20 сая төгрөгийн торгуулийн ялыг биелүүлэхэд бодит нөхцөл боломж бий эсэх нь эргэлзээтэй байна. Үүнээс Үзэхэд Эрүүгийн шинэ хуульд заасан торгуулийн ялын хэмжээ өнөөгийн амьдралд нийцэхгүй байна гэж үзэх үндэслэлтэй тул энэ талаар цаашид нарийвчлан судалж Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх хэсэгт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч нэг жилийн хугацаа өнгөрсөн бол шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн гэж үзэж ялтны үндсэн ба нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй гэж заасан. Эрүүгийн хуулийн энэ заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар онцгой анхаарах нь зүйтэй. Дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн дээрх заалт нь торгох ялаас "ноцтойгоор зайлсхийгээгүй" хүн бүрт холбогдож түүнийг хэрэгжүүлэх ёстой гэсэн ойлголт байгаа нь ч нууц биш юм.

Өнөөдөр олон сая төгрөгийн торгууль хүлээсэн хүн хорих ялаар сольж өгөх хүсэлт гаргаж шүүхүүдэд ханддаг болсон тухай анхан шатны шүүхүүд мэдээлэл өгч байна. Ийм хүмүүст оногдуулсан торгох ялыг Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр өөрчлөх үндэслэлгүй гэж

үэнэ. Иймд Эрүүгийн хуулийн дээрх тодорхой заалтуудад өөрчлөлт оруулах талаар эрх бүхий байгуулагуудад санал оруулах нь шаардлагатай гэж үзнэ.

Эрүүгийн шинэ хууль үйлчилж эхэлсэн өдрөөс торгуулийн ял шийтгүүлэн уг ялыг биелүүлээгүй ял шийтгүүлэгчдийн дийлэнх нь ноцтойгоор энэ ялаас зайлсхийж, оргон зайлаагүй болох нь тогтоогдож байгаа бөгөөд торгуулийн ялыг биелүүлэх төлбөрийн чадваргүй байдлаас болж уг ялаа биелүүлж чадахгүйд хүрчээ. Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76,1.1 дэх хэсэгт зааснаар торгуулийн ялаас чөлөөлөх асуудлыг ч авч үзэж байвал зохино. Ингэхдээ уг ялаас санаатай зайлсхийсэн, оргон зайлсан эсэхийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 336 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагаас нь шалган тогтоолгосны эцэст шийдвэрлэж байхыг зөвлөж байна.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ  
ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ